

Анхан болон лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн Хавдрын тусламж, үйлчилгээ
хариуцсан мэргэжилтэн Г.Хулангийн
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/			
ЗОРИЛТ 1. ХАВДАР, ХӨНГӨВЧЛӨХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРТ, ДУНД, БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДСЭН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД								
					Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/331 дүгээр тушаалаар “Хавдраас сэргийлэх, хянах” хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/350 дугаар тушаалаар “Зонхилох байрлалын хавдрын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний талаарх бодлогын санал гаргах, хөтөлбөр боловсруулах”-дэд ажлын хэсэг;			
1	Дэд арга хэмжээ 1.1.1: Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөрийн төслийг боловсруулж, холбогдох саналыг тусган батлуулна.	Батлагдсан хөтөлбөр (тоогоор)	0	1	2024 оны А/351 дугаар тушаалаар “Ходоод, улаан хоолой, бүдүүн-шулуун гэдэсний хорт хавдар”, 2024 оны А/352 дугаар тушаалаар “Уушгины хорт хавдар”, 2024 оны А/353 дугаар тушаалаар “Хөхний хорт хавдар”, А/354 дугаар тушаалаар “Элэгний хорт хавдар”, А/355 дугаар тушаалаар “Умайн хүзүүний хорт хавдар”-ын дэд ажлын хэсгүүдийг тус тус байгуулсан. Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд ажлын хэсэг нийт 12 удаа танхимаар		01-06	90%

					хуралдаж, дэд ажлын хэсгүүдээс гарсан саналын дагуу хөтөлбөрийн төсөл, 8 дэд төлөвлөгөөний төслийг боловсруулж, шаардлагатай санхүүжилтийг СЭЗБГ-тай хамтран тооцоолсон. Хөтөлбөрийн төслийг Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/350 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэгт 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/331 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэгт 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр, хүүхэд, цусны хорт хавдар, Хавдар судлалын үндэсний төв-2-ын байгуулах асуудлаар 2025 оны 02 дугаар сард ажлын хэсэгт тус тус танилцуулж, хурлын шийдвэрийн дагуу гарсан саналыг тусгасан. Хөтөлбөрийг Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, гишүүдээс гарсан саналыг тусган, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулахаар, газрын дарга нараар тойруулж байна.		
2	Дэд арга хэмжээ 1.2.1: Туяа эмчилгээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулан төслийг боловсруулж, холбогдох саналыг тусган батлуулна.	Батлагдсан ажлын хэсэг, боловсруулсан төсөл	0	Туяа эмчилгээний төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулж, төлөвлөгөөний төслийг боловсруулсан байна.	Хавдрын туяа эмчилгээний урт хугацааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг нийт 3 удаа хуралдаж, төлөвлөгөөний үндэслэл буюу хэрэгцээ шаардлага, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон. Ажлын хэсгээс гарсан саналын дагуу туяа эмчилгээ, цөмийн оношилгоо, эмчилгээний хэсгийн дэд бүлэг байхаар төслийг боловсруулсан.	01-06	100%
3	Дэд арга хэмжээ 1.3.1: Хорт хавдрын эрт илрүүлгийн	Батлагдсан журамд (тоогоор)	0	Эрт илрүүлгийн эрхзүйн орчныг бүрдүүлэх, зохион	Зонхилох байрлалын буюу элэг, ходоод, улаан хоолой, бүдүүн-шулуун гэдэс, уушги, хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт	01-06	100%

	зохион байгуулалтыг төлөвлөж, эрт илрүүлгийн журамд тусгана.			байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	илрүүлгийн үзлэг, оношилгоог үндэсний хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд баг тус бүр 1 удаа, дэд ажлын хэсгүүд хамтран 6 удаа, нийт 12 удаа танхимаар хуралдаж, эрт илрүүлэг зохион байгуулах алгоритм, шаардлагатай тоног төхөөрөмж, хүний нөөц, эдийн засгийн судалгааг гаргасан. Энэ ажлын хүрээнд ЭМС-ын 2025 оны 04 дүгээр тушаал, ЭМДҮЗ-ийн 2025 оны 10 дугаар "Журам, төлбөрийн хэмжээ батлах тухай" тогтоолоор "Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд зорилтот бүлгийн даатгуулагчийг хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх журам", "Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд зорилтот бүлгийн даатгуулагчийг хамруулах товлал, давтамж болон зардлын төлбөрийн хэмжээ" тус тус батлагдаж, эрх зүйн орчин бүрдсэн. Одоогийн байдлаар нийслэлийн хэмжээнд эрт илрүүлэг, оношилгоо хийх сургалтыг зохион байгуулсан ба орон нутагт сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.		
ЗОРИЛТ 2. ХАВДАР, ХӨНГӨВЧЛӨХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЭЛ ЧИРЭГДЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД							
1	Дэд арга хэмжээ 2.1.1: Зонхилон тохиолдох байрлалын хорт хавдрын эрт илрүүлгийн зааврын төслийг боловсруулж, холбогдох байгууллага,	Хэлэлцүүлгийн тоо (тоогоор)	0	2	Зонхилон тохиолдох байрлалын хорт хавдрын эрт илрүүлгийн зааврын төслийг Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/351 дугаар тушаал "Ходоод, улаан хоолой, бүдүүн-шулуун гэдэсний хорт хавдар", 2024 оны А/352 дугаар тушаал "Уушгины хорт хавдар", 2024 оны А/353 дугаар тушаал "Хөхний хорт хавдар", А/354 дугаар тушаал "Элэгний хорт хавдар", А/355 дугаар "Умайн хүзүүний хорт хавдар" тушаалаар	01-06	100%

	мэргэжлийн салбар зөвлөлөөс санал авч, хэлэлцүүлнэ.				батлагдсан дэд ажлын хэсгүүд хамтран боловсруулсан. Холбогдох мэргэжлийн салбар зөвлөлүүдээс саналыг 2025.02.29-ний 6/926 дугаар албан бичгээр авсан. Мэргэжлийн салбар зөвлөлөөс ирсэн саналыг тусган, зааврын төслийг дахин хэлэлцүүлж, сайжруулалт хийсэн ба холбогдох мэргэжлийн нийгэмлэгийн саналыг мөн тусгасан. Одоогоор зааврын төслийг хэлэлцэж, эцэслэн, ЭМЯ-ны газрын дарга нараас санал авахаар бэлтгэж байна.		
2	Дэд арга хэмжээ 2.2.1: Зонхилон тохиолдох байрлалын хорт хавдрын оношилгоо, эмчилгээний зааврын төслийг боловсруулсан байна.	Зааврын төслийн тоо (тоогоор)	0	5	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/351, А/352, А/353, А/354, А/355 дугаар тушаалаар байгуулсан дэд ажлын хэсгүүд зонхилон тохиолдох байрлалын буюу ходоодны хорт хавдар, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар, элэгний хорт хавдар, хөхний хортой хавдрын заавар, хөхний хоргүй хавдрын заавар, бай эмчилгээний зааврын төслийг боловсруулсан. Холбогдох зөвлөлүүдэд хэлэлцүүлэхэд бэлдэж байна.	01-06	100%
3	Арга хэмжээ 2.4: Эрүүл мэндийн салбарын бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалтаар хангах	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнгийн тайлан	0	Бүсчилсэн хөгжлийн нэгдсэн зохион байгуулалтаар хангах менежерийг томилох, хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөсөн байна.	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/72 дугаар "Бүсийн менежер томилох тухай" тушаалаар 6 бүс, Улаанбаатар хотын бүсийн менежерүүд томилогдсон. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн "Хавдар судлалын үндэсний төвд бүс хариуцсан менежерүүд ажиллах удирдамж"-ийн дагуу эн тэргүүнд хавдрын тусламж, үйлчилгээний бүсчилсэн хөгжлийн төлөвлөлтийг гаргахаар ажилласан. Энэ ажлын хүрээнд нийт 6 удаа танхимаар ажиллаж, хавдрын тусламж, үйлчилгээний бүсчилсэн хөгжлийн зураглалыг гаргасан. Хойд бүсийн бүсчилсэн хөгжлийн Засгийн газрын хуралдаанд 2025.04.28-ны өдөр	01-06	100%

					оролцсон ба хуралдаанаар Эрдэнэт хотын “Эрдэнэт Медикал” эмнэлгийг Хавдар судлалын үндэсний төвийн харьяа оношилгоо, эмчилгээний төв болгох асуудал дэмжигдсэн.		
4	Арга хэмжээ 2.5: Итгэл найдварын туяа төслийн хүрээнд санхүүгийн баримт бичиг “Bankable document” боловсруулсан байна.	Боловсруулсан төслийн баримт бичиг	0	Санхүүгийн баримт бичгийг боловсруулсан байна.	Итгэл найдварын туяа төслийн санхүүгийн баримт бичиг “Bankable document”-ийг боловсруулах баг Эрүүл мэндийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/10 дугаар тушаалаар байгуулагдсан. Ажлын хэсгийн гишүүд баримт бичигт шаардлагатай мэдээллийг цуглуулж, 2025.05.12-2025.05.16-ны өдрүүдэд Австри улсын Вен хотод ОУАЭА-с зохион байгуулсан сургалтад хамрагдаж, баримт бичгийн төслийг боловсруулсан. Баримт бичгийн төслийг сайжруулах зөвлөх 2025.06.17-2025.07.01-ний өдрүүдэд цахимаар хамтран ажиллаж, төслийг эцэслэхээр төлөвлөж байна.	01-06	100%

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх-түвшин	Хүрсэн-түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. “Эмчээ сонсьё” арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ-1	-	Арга хэмжээг зохион байгуулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/85 “Тэмдэглэлт өдөр зохион байгуулах тухай” тушаалаар Дэлхийн эмч нарын өдөр, Олон улсын сувилагч нарын өдөр, Олон улсын эх баригчдын өдрийг зохион байгуулахад баримтлах чиглэлийг баталсан. Уг тушаалын дагуу Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан “Эмчээ сонсьё” арга хэмжээг 2025 оны 3 дугаар сарын 27-ноос 4 дүгээр сарын 4-ний	01-06	100%

					өдрийн хооронд танхим, цахим хосолсон уулзалт хэлбэрээр Эрүүл мэндийн яамны Б зааланд зохион байгуулсан. Арга хэмжээнд танхимаар 45 эрүүл мэндийн байгууллагын 428 эмч, цахимаар 21 аймгийн 400 гаруй эмч нар оролцсон.		
2	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. "Хавдрын цогц шинэчлэл" зөвлөгөөн зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ-1	-	Арга хэмжээг зохион байгуулсан байна.	"Хавдрын цогц шинэчлэл" зөвлөгөөнийг 2025.06.07-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнөөр хавдрын тусламж, үйлчилгээнд баримталж буй бодлого шийдвэрийг танилцуулсан ба Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөрийг хэлэлцүүлсэн. Зөвлөгөөнд ЭМЯ-ны харъяа байгууллагууд, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгийн захирал нар, лавлагаа шатлалын хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагууд, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга нар, хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөл, хавдар судлаач эмч нар, хавдрыг даван туулагч нарын төлөөлөл, нийт 240 хүн оролцсон.	01-06	100%
3	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Сайдын нэрэмжит спортын тэмцээн зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ-1	-	Арга хэмжээг зохион байгуулсан байна.	Эрүүл мэндийн сайдын нэрэмжит спортын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэгт хөтөлбөр хариуцсан менежерээр ажилласан. Тус арга хэмжээ нь спортын 6 төрлөөр 2025.03.24-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.	01-06	100%

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
"ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							

1.	Арга хэмжээ 1.1: Албан тушаалын онцлогоос хамаарсан гадаад хэл, мэдээллийн технологийн болон салбарын хууль тогтоомжид заасан зайлшгүй шаардлагатай ур чадварыг мэргэжлийн байгууллагаар дамжуулж, эсхүл бие даан суралцаж эзэмшинэ.	Сургалтад бүрэн хамрагдаж, багц цагийг биелүүлэх эсхүл шалгалт өгч гэрчилгээ авсан байх (Тийм:1 / Үгүй:2)	-	1	PRIMIS EDUCARE сургалтын төвд IELTS-ийн шалгалтад бэлдэх эрчимжүүлсэн 2 сарын сургалтад 2025.2-4 сард хамрагдаж төгссөн.	I-IV улирал	100%
2.	Арга хэмжээ 1.2: Хувь хүний хөгжлийн сургалтад хамрагдсан байна.	Сургалтад бүрэн хамрагдаж, багц цагийг биелүүлэх эсхүл шалгалт өгч гэрчилгээ авсан байх (Тийм:1 / Үгүй:2)	-	1	БНӨМӨЗО-ны Хөх хотод зохион байгуулагдсан хүүхдийн өвчин, хавдрын сэргээн засах уламжлалт эмчилгээний сургалтад 2025.04.12-04.19-ний хооронд хамрагдаж төгссөн.	I-IV улирал	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эмнэлгийн тусламжийн бодлогын
газрын Анхан болон лавлагаа
шатлалын тусламжийн хэлтсийн
Хавдрын тусламж, үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн

Г.Хулан / *Г. Хулан* /

2025 оны 06 сарын 13

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
5 дугаар хавсралт


НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС (ЗАГВАР)

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)

Д/д	Үүрэг даалгавар	Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. "Эмчээ сонсьё" арга хэмжээг зохион байгуулах	Эрүүл мэндийн сайд	Зохион байгуулсан арга хэмжээ-1	-	Арга хэмжээг зохион байгуулсан байна.	2025. 03.27	2025. 04.04
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. "Хавдрын цогц шинэчлэл" зөвлөгөөн зохион байгуулах	Эрүүл мэндийн сайд	Зохион байгуулсан арга хэмжээ-1	-	Арга хэмжээг зохион байгуулсан байна.	2025. 06.02	2025. 06.07
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Сайдын нэрэмжит спортын тэмцээн зохион байгуулах	Төрийн нарийн бичгийн дарга	Зохион байгуулсан арга хэмжээ-1	-	Арга хэмжээг зохион байгуулсан байна.	2025. 03.24	2025. 03.30

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:


Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын
Анхан болон лавлагаа шатлалын
тусламжийн хэлтсийн Хавдрын тусламж,
үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Г.Хулан /  /

2025 оны 03 сарын 07.

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын
Анхан болон лавлагаа шатлалын
тусламжийн хэлтсийн дарга

С.Жаргалсайхан /  /

2025 оны 03 сарын 07.